

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН**



Шинэ номын мэдээ

2019

№ 03

Эмхтгэсэн: Ном зүйч С.Найгалмаа

**Электрон каталог:
<https://catalog.num.edu.mn>**

ГАРЧИГ

ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
ГЕОЛОГИ, ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....	2
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	3
ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	3-4
ХИМИЙН ТЕХНОЛОГИ. ХИМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ.....	4
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	5-7
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	7-9
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	9-10
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	10-12
ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	11-12
ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ.	13-14
БОЛОВСРОЛ БА СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН.....	14-15
СЭТГҮҮЛ ЗҮЙ, НОМ СУДЛАЛ.....	15-17
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	17-18
УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ.....	18
УРАН ЗОХИОЛ.....	18-22
УРЛАГ СУДЛАЛ.....	22-25
ШАШИН СУДЛАЛ.....	25-26
ГҮН УХААНЫ ШИНЖЛЭХ УХААН.....	26
СЭТГЭЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААН	26-27
ЛАВЛАГАА НОМЗҮЙН ГАРЫН АВЛАГА.....	27

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ-Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/
НХУУТ-Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим- I, II /211, 108 тоот/
ГНОФ-Гэрээр ном олгох фонд-I, II, III /110, 201, 401 тоот/
ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/
ЛавФ- Лавлагааны фонд- /409 тоот/
БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/
ХЗС-Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/
ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын
сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

ХИМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Даржаа Ц. **Ерөнхий хими**: Их, дээд сургуулийн сурах бичиг / Ред. Д.Дорж.-Здахь хэвл.- УБ.: Адмон принт, 2019.- 463х.- ISBN: 978-9919-21-181-3.



Их, дээд сургуулийн оюутан сурагчдад зориулагдсан энэ номонд ерөнхий химийн үндсэн агуулга, химийн бодисын харилцан үйлчлэл, химийн урвал, термохими, цахилгаан химийн талаар өгүүлжээ.

24.1я73

Д 358

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-22924-22926

Хэрэглээний хими: Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг / Ш.Оюунчимэг, А.Алтанзул, Г.Отгондэмбэрэл ба бус.; Хян. Х.Хүрэлтогоо.- УБ.: Бемби сан, 2018.- 400х.- ISBN: 978-99978-3-329-7.



Энэ сурах бичиг нь хэрэглээний химийн агуулгыг бүрэн багтаасан анхны монгол ном гэдгээрээ онцлог юм. Номын 1-7-р бүлэгт сэргээгдэх буюу үл сэргээгдэх эрчим хүч, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ, 8-10-р бүлэгт цахилгаан химийн үндэс, 11-14-р бүлэгт бодисын химийн найрлага, бүтэц шинж чанар хэрэглээ, 15-17-р бүлэгт усны физик химийн шинж, хаягдал ус ашиглах технологид суурилсан полимерүүд идэвхижүүлсэн болон нийлмэл материалуудын найрлага шинж чанар, хэрэглээг дэлгэрэнгүй авч үзсэний дээр төгсгөлд хагас дамжуулагч нано технологийн талаар товч өгүүлжээ. Бүлгүүдийн төгсгөлд бие дааж ажиллах дасгалууд мөн эх орны боловсруулах үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний экспорт, импорт хэрэглээний товч мэдээлэлийг оруулсан байна.

24я73

Х 931

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-22874-22876

Даваадорж Д. **Химийн нэгдлүүд ба хольцуудын хор, аюулыг "ангилах, зэрэглэх ба хаягжуулах" шалгуур үзүүлэлтийг ашиглах удирдамж**: Химийн шинжээчийн гарын авлага / Ред. Ч.Баттулга.- УБ.: Бэмби сан, 2019.- 853х.- (Байгаль Орчны Нөлөөллийн нарийвчилсан Үнэлгээ, Зөвлөх Үйлчилгээний Флоурексон ХХК).- ISBN: 978-99978-68-40-4.



CLP шалгуур үзүүлэлтүүдийг ашиглахад зориулсан энэхүү удирдамжийн гол зорилго нь химийн нэгдлүүд болон хольцуудын физикийн аюул, хүний эрүүл мэнд ба байгаль орчинд учруулах хор, аюулыг дээрхи шалгуурын дагуу ангилж, ашиглах талаар нарийвчилсан зааварчилгаагаар хангахад оршино. Тус бүтээл нь дэлхий нийтээрээ даган мөрдөж буй энэ зохицуулалтын системийг манай улсад нэвтрүүлэн мөрдөж ажиллахад туслах чухал гарын авлага болно.

24я2

Д 121

/БУУТ-3/

ЭШФ Т-22838-22840

ГЕОЛОГИ, ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

Мөнхтоого Л., Эрдэнэбат Б. **Нүүрсний хайгуулчдын гарын авлага** / Ред. Ө.Энхтөгс, Н.Байгалмаа.- УБ.: МУИС пресс, 2019.- 219х.- ISBN: 978-99978-69-04-3.



Гарын авлага нь 5 хэсэгтэй бөгөөд нэг, хоёрдугаар хэсэгт шатах ашигт малтмал геологийн номноос авч, гуравдугаар хэсэгт ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг нүүрсний хайгуулд хэрэглэх зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэх аргачлалыг оруулсан байна. Дөрөвдүгээр хэсэгт ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зөвлөмжийг бүрэн эхээр нь багтааж, тавдугаар хэсэгт нүүрсний хайгуулын ажил явуулахтай холбоотой гарсан заавар, зөвлөмжийг хавсралтаар оруулжээ.

26.343.3

М 816

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-29384-29386

Шаандар П. **Металл бус ашигт малтмалын ордын эрлийн цогцолбор арга** / Ред. Ж.Лхамсүрэн, П.Дугараа. – УБ.: Соёмбо принтинг, 2018.- 536х.- ISBN: 978-99978-3-924-4.



Энэхүү номонд эрлийн ажлын тухай, уулын малтмал, геологийн зураглал, минералогийн судалгааны арга, өрөмдлөгийн ажил, эрлийн геохими, геофизикийн судалгааны аргууд, геофизикийн судалгааны техник хангамж гэх мэт сэдвийн хүрээнд дэлгэрэнгүйгээр өгүүлжээ.

26.342

Ш 101

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-22921-22923

Дэлхий судлалын үндэс / Г.Юмчмаа, С.Эрдэнэсүх, Д.Даваадорж ба бус.; Ред. Г.Юмчмаа, С.Эрдэнэсүх.- Анхны хэвл.- УБ.: Адмон, 2019.- 319х.- (МУИС. ШУС. БУС, Газар зүйн тэнхим).- ISBN: 978-99978-58-85-6.



Сансар огторгуй, од гараг эрхэс, нарны аймаг болон орчлон ертөнцийн зүй тогтлыг шинжлэх ухааны үндэстэй судлан тайлбарласан энэхүү сурах бичиг нь эх дэлхийнхээ үүсэл хөгжил болоод өнөөгийн тулгамдсан асуудлыг танин мэдэхэд туслах юм. Тус сурах бичгийн бүлэг бүрт тухайн сэдвийн судалгааны түүхийг дэлгэрэнгүй оруулж, тоо баримт, сонирхолтой мэдээлэлийг нэмэлтээр шигтгэж, гүнзгийрүүлэн судлах хэсэгт бодлого, тайлбар, тухайн сэдвийн дүгнэх асуулт даалгавар оруулж өгсөн оюутнуудыг чиглүүлэх ач холбогдолтой, семинарын хичээлийг шинжлэх ухааны баримтат кинонд тулгуурлан боловсруулсан учир хичээлийн явцад ч номоо бүрэн ашиглах боломжтой ажээ.

26.89(0)я73

Д 893

/БУУТ-10, ГНОФ-17/

ЭШФ Т-22781-22783

БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Оюунтуяа А. **Загасны аж ахуй** / Хян. Н.Төмөртогтох, Б.Энхжаргал.- УБ.: Адмон принт, 2018.- 212х.- ISBN: 978-99978-3-788-2.



Энэхүү сурах бичгийн нэгдүгээр бүлэгт загасны анатоми, морфологийн тухай ойлголтууд, хоёрдугаар бүлэгт загасны ашиг шимийн үзүүлэлтийг тооцох аргачлал, гуравдугаар бүлэгт Монгол орны загасны төрөл, зүйл, тэдгээрийн био экологи болон ашиглалт, хамгаалалтын асуудал, дөрөвдүгээр бүлэгт загас үржүүлэх технологи, тавдугаар бүлэгт цөөрмийн аж ахуйн ангилал, аж ахуй эрхлэлт, зургаадугаар бүлэгт загас, загасан бүтээгдэхүүн боловсруулах арга технологийн талаар өгүүлнэ. Загасны аж ахуй эрхлэгч, загас сонирхогч, загас үржүүлэг технологийн мэргэжлээр мэргэшиж буй оюутан залууст зориулав.

47.2я73

О-634

/БУУТ-3/

ЭШФ Т-2022841-2022843

ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Электроникийн үндэс: Лабораторийн хичээлд зориулсан гарын авлага / Б.Ганбат, Э.Дамдинсүрэн, Д.Данзан, Ж.Нямжав; Ред. Д.Бямбажав.- 3 дахь хэвл.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2019.- 109х.- (МУИС. Хэрэглээний Шинжлэх Ухаан Инженерчлэлийн Сургууль).- ISBN: 99919-21-265-0.



Нэмэн сайжруулсан энэхүү гарын авлагын онолын хэсэгт тухайн сэдвийн онолын үндэс болон хэлхээний бүтэц, ажиллах зарчмыг дэлгэрэнгүй тайлбарлаж, томъёоны гаргалгааг гүйцэтгэж, баяжуулсан. Юуг хэмжих, ямар дохио гаргах мэтийг хялбар ойлгуулах үүднээс дохионуудыг хэмжилтийн багаж дээр харагдаж байгаагаар нь үзүүлж мөн хэмжих багажтай ажиллах, хэмжилтийн утгыг зөв тэмдэглэж авах, график байгуулах, туршилтын үр дүнгээ зөв боловсруулах чадваруудыг эзэмшихэд зориулсан тус гарын авлага нь электроникийн үндсийг сонирхон судалж буй нийт оюутнуудад зориулжээ.

32.85я2

Э 43

/БУУТ-45, ГНОФ-150/

ЭШФ Т-22895-22899

Pedroni, Volnei A. **VHDL тоон хэлхээний загварчлал** / Ред. Б.Зоригтбаатар, Д.Эрдэнэчимэг; Орч. Б.Луубаатар, Ц.Сугир.- УБ.: ШУТИС-ийн хэвлэл, 2019.- 227х.- ISBN: 978-99978-69-722.



Энэхүү ном нь хэлхээний загварчлал, системийн загварчлал гэсэн хоёр үндсэн агуулгатай ба кодын үндсэн бичилтийг тайлбарлаж, хэрэглэгчийн сан (Library) зохион байгуулах, ашиглах тухай (код хамтран хэрэглэх, ахин хэрэглэх хувиарлах гэх мэт) үндсэн сэдвийг тусгасан болно. Номыг их дээд сургуулийн электроник, микроэлектроник, чип дизайн, тоон хэлхээний загварчлал чиглэлийн хичээлүүдэд сурах бичиг болгон хэрэглэхэд зориулав.

32.973-018я73

Р 36.

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-22918-22920

Программчлалын хэл Python хялбар сурах нь / Орч. Р.Төрбат; Ред. Б.Сонинцэцэг.- УБ.: ШУТИС хэвлэх, 2018.- 207х.- ISBN: 978-99978-2-207-9.



Энэ сурах бичиг нь програмчлалын талаар анхлан суралцагсдад зориулагдсан бөгөөд тэдэнд хялбар байх үүднээс эрэмбэ дараатай ажиллах дасгалыг голчлон оруулсан төдийгүй суралцагч үндсэн ба нэмэлт дасгалуудыг ажиллах буюу цээжлэх аргаар Python-ыг хэрхэн хялбар сурахад чиглүүлэн хөтлөх болно.

32.973-018.1я73

П 784.

/БУУТ-5/

ЭШФ Т-22844-22846

Ганбат Ц., Сарангэрэл Д. **Мэдээлэл хайлтын үндэс: Их сургуулийн үндсэн сурах бичиг** / Хян. Д.Бадарч, Н.Чулуунбанди.- Анхны хэвл.- УБ.: ШУТИС-ийн хэвлэх үйлдвэр, 2019.- 207х.- (Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль. Мэдээлэл, Холбооны Технологийн сургууль).- ISBN: 978-99978-68-71-8.



Зохиолчид энэ сурах бичигтээ мэдээлэлийг интернэтээс хайх хайлтын системийг хөгжүүлэх, машин сургалтын аргуудыг хэрэглэж хайлтын үр дүнг олох, эрэмбэлэх, оновчлох, хайлтаар олдоогүй тохиолдолд ойролцоо болон төсөөтэй үр дүнг олох, алдаатай query-г засаж үргэлжлүүлэн хайх, хайлтын системийг үнэлэх технологиудыг танилцуулж, эдгээр аргуудыг ашиглан шинжлэх ухааны болон нийгмийн бүх салбарт хуримтлагдсан мэдээлэлийн их өгөгдлөөс оновчтой хайлт хийхэд туслах аргачлалыг заасан уг бүтээлд 97 зураг, 25 хүснэгт, 22 алгоритм, 49 математик томъёо, 52 жишээ, 87 дасгал, 52 мэргэжлийн нэр томъёоноос бүтжээ.

32.973я73


Г 21

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ-22877-22879

ХИМИЙН ТЕХНОЛОГИ. ХИМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

Эрдэнэчимэг Д. **Үнэт, өнгөт металлын хими технологи: Сурах бичиг** / Хян. Р.Санжаасүрэн, А.Цэцэгмаа.- УБ.: МУИС пресс, 2019.- 348х.- ISBN: 978-99978-2-865-1.



Энэ ном нь агуулгын хувьд үндсэн 5 хэсэгтэй бөгөөд эхний хэсэгт металлургийн үндсэн ойлголт болох металлын шинж чанар, тэдгээрийн ангилал, металл ялган авах арга, металлургийн үндсэн процессууд, хэрэглэгдэх тоног төхөөрөмж, хүдрийн бэлтгэл ажиллагаа, дараагийн хэсэгт түүхий эдийг баяжуулах аргууд, 3-р хэсэгт хөнгөн цагааны технологийн талаар, 4-р хэсэгт нь зэсийн боловсруулах технологи, 5-р хэсэгт алт, мөнгө боловсруулах технологийн талаар тус тус тодорхой бичсэн энэхүү сурах бичгийг металл боловсруулалтын чиглэлээр суралцагсад, мэргэжилтнүүдэд зориулан хэвлэсэн байна.

35

Э 739

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29324-29326

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Алтанзаяа Л. **Ойрад монголчуудын соёл: XVII-XVIII зууны дунд үе** / Ред. А.Очир.- УБ.: Хаан принтинг, 2010.- 192х.- ISBN: 978-99962-55-14-4.



Судлаач энэ бүтээлдээ Ойрадын нэгэн хагас зууны соёлын түүхийг цогц байдлаар тусгайлан авч үзэхдээ тухайн сэдэвт холбогдох сурвалж бичгүүд болон судлагдсан байдлыг нарийн нягт судалсан бөгөөд тэрхүү нөр их судалгааны үр дүнгээ нэгтгэн гаргасан энэхүү бүтээлээс уншигч та XVII-XVIII зууны дунд үеийн Ойрадын ард түмний аж ахуйн мэдлэг, эд өлгийн соёл, гар үйлдвэр урлал, тэдний төр ёсны болоод оюуны соёл, хууль зүй, бичиг үсгийн соёлд холбогдох түүхийн нэн чухал мэдлэгийг авах буй заа.

63.3(1)51

А 486.

ЭШФ Б-29343

Намжил Т. **Монголын нууц товчоо-Монголчуудын гэр бүлийн түүх, уламжлалын судалгааны үнэт эх сурвалж болох нь: Түүх, угсаатан зүй, сурган хүмүүжлийн судалгаа** / Ред. Н.Бэгз, Го.Гэрэлмаа.- УБ.: Бит пресс, 2019.- 176х.- ISBN: 978-99978-67-27-8.



Дэлхий дахинаа сүүлийн жилүүдэд түүх, угсаатны зүй, овог, аймаг, гэр бүлийн судалгааг эрчимтэй өрнүүлээд байна. Тус номонд монголчуудын түүх угсаатны зүй, гэр бүлийн түүх, уламжлалын талаар өгүүлэх бөгөөд эрдэмтэн судлаачид, багш, сурган хүмүүжүүлэгчид, улмаар суралцагчдад сургалтын хэрэглэгдэхүүн болгон гэр бүл иргэдэд зориулан гаргав.

63.5(1)+84(1)

Н 256

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-29367-29369

Дөш М. **Монголын зуун суут хүн Түүх-намтрын товчоон= Mongolian the 100 most influential people** / Ред. А.Самбуу.- УБ.: Сэлэнгэпресс, 2016.- 157х.




Тус номонд Монголчуудын дотроос төрж гарсан суу билигт хаад, ноёд, цэргийн зүтгэлтнүүд, эрдэмтэн мэргэд, зохиолч яруу найрагчдын алдар гавьяа, тэдний үйл хэргийн талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Суут хүмүүний одонд төрсөн эдгээр 100 хүний намтар бол монголчуудын их бахархал бөгөөд тэднийг бүхэлдээ монголчуудын түүхийг бүтээгчид гэдэгтэй маргахгүй бизээ.

63.3(1)-8

Д 619

ЭШФ Т-22937-22938

Нямаа Б. **Монголын эзэнт гүрний зоосон мөнгө ба хаадын овгийн тамга: XIII-XIV зуун** = **The coins of Mongol empire and clan tamgha of khans: XIII-XIV** / Зөвл. Ц.Батсайхан, П.Н.Петров, Жон Е.Вүүдс; Орч. Э.Буяндэлгэр; Ред. Б.Туул.- УБ., 2005.- 254х.- ISBN: 99929-0-423-2.



Зохиогч энэ номондоо Монголын эзэнт гүрний хаадын овгийн зоосон бөгөөд цаасан мөнгө, тамгыг тодорхойлжээ.

63.3(1)43

Н 985

ЭШФ Т-22936

Адъяаа Ш. **Галдан Бошигт** / Хян. Д.Баасанбат.- 2 дахь хэвл.- УБ., 2019.- 125х.- ISBN: 978-99978-66-54-7.



Зохиогч Галдан хааны түүхэнд холбогдох олон эх сурвалжаас судлан цуглуулж, эмхлэн найруулсан энэхүү бүтээлд Галдан хаан болбоос Монгол гаралтай, их Богд Зонховын үүсгэсэн шарын шашны үйл хэргийг залгамжлан дэлгэрүүлж, морин дэл дээрээс Төв Азийн Тэн хагасыг захирч, туг сүлд нь болж явахдаа, туурга тусгаар Монголынхоо язгуур эрх ашгийг нэгээхэн ч удаа умартаж байгаагүй эх оронч байсан төдийгүй ард олноо асран энэрч, сэтгэлийг хураах увидастай удирдагч байсан түүхийг нотлох баримтаар хойч үедээ таниулан үлдээхийг зорьсон байна. Энэ ном нь анхны хэвлэлээ нэмэн баяжуулж, шинэтгэл оруулсан хоёр дахь хэвлэл нь юм.


63.3(1)42

A 297

/НХУУТ-10, ГНОФ-12/

ЭШФ Т-22890-22894

Ундрам Ч. **Миний өвөө Пунцагийн Дорж**: Халхын голын дайны ялалтын 80 жилийн ойд зориулав / Ред. Д.Тунгалаг, Б.Наранцацралт.- УБ.: Голден легион, 2019.- 80х.- ISBN: 978-9919-22-005-1.



Пунцагийн Дорж нь эх орныхоо тусгаар тогтнол, ард түмнийхээ эрх чөлөөт байдлын төлөө алтан амиа үл хайрлан тулалдсан зоригт монгол хөвүүдийн нэг юм. Тиймээс зохиогч энэ номондоо тухайн үеийн дайны хүндийг үүрч, тусгаар тогтносон Монгол улсыг бидэнд өвлүүлэн үлдээж, улс нийтээрээ хөгжин дэвшихэд хөдөлмөр, зүтгэлээ зориулсан ахмад үеийн төлөөлөл болгож өөрийн аав, өвөөгийн хөө алдар гавъяаг мөнхжүүлсэн энэхүү намтар дурсамжийн номыг бүтээж уншигч олондоо өргөн барьжээ.

63.3(1)-8

У 368

ЭШФ Т-22933-22935

Баасандорж Г. **Баян-Уулын хадны зураг** / Зөвл. Д.Цэвээндорж; Ред. Н.Батболд.- УБ.: 2018.- 143х.- ISBN: 978-99978-3-295-5



Энэ номонд Бараан хад, Асган ус, Өвөрхадны ихэр, Бэрхийн дотор хашаат, Шүүт, Ловонгийн хуруу, Салхит, Ягаан орой, Улаан хондны бууц, Замын өтөг,

Гэр чулуу, Санзын хонд, Дуулга орчмын урьд өмнө судалгаанд ороогүй нийт 267 гаруй дурсгалын судалгааг оруулсан.

63.4(1)

Б 109

ЭШФ Т-22931-22932

Цас Ж. **Сүлд ба далбаа юуг өгүүлнэ вэ?** / Хян. Б.Наран.- УБ.: Очирпресс, 2019.- 160х.- зур.- ISBN: 978-99192-14-814.



Аливаа улс үндэстэн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа хэмээн өөрийн туг сүлдийг бий болгодог. Энэ бүтээлд зохиогч улс орнуудын сүлдний үүсэл, бүтэц хэрэглээ, бэлэгдэлийн талаар түүхийн эх сурвалж, баримт судалгаанд үндэслэн дэлхийн улсуудын сүлд, туг, далбааг судлан тайлбарлажээ. Уг бүтээлийн төгсгөлийн бүлэгт МУ-ын сүлд ба далбааны түүх, өөрчлөлт шинэчлэлт, өнөөгийн сүлдний тухай, соёмбын тухай судлаачийн өөрийн хийсэн дэлгэрэнгүй баримтууд багтсан байна.


63.3

Ц 23

/НХУУТ-7/

ЭШФ Т-22835-22837

Окада Хидэхиро. **Чингис хаан түүний үр сад** / Орч. П.Наранбаяр; Ред. Т.Мөнхцэцэг.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 199х.- (МУИС. Монгол Судлалын Хүрээлэн).- ISBN: 978-99978-58-83-2.



Анхны хэвлэл нь уншигч олны талархал хүлээж эдүгээ олдохуйяа бэрх болсон эл бүтээлээ зохиолч хянан сайжруулж, дахин хэвлүүлсэн байна. Уг бүтээлд Чингис хааны зан чанар, үйл хэрэг болон эртний нүүдэлчдийн эзэнт гүрнүүдийн тухай, Чингисээс хойшхи Монголын эзэнт гүрэн өнөөг хүртэлхи түүхийг хамран өгүүлэхдээ Монголын нууц товчооны домог яриаг түлхүү оруулсан нь онцлог болжээ.

63.3(1)41

О-25

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-22810-22812

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Ажил мэргэжил судлалын нэр томъёоны тайлбар толь / Ред. Д.Гомбо, Б.Туяа.- УБ.: Удам соёл, 2019.- 422х.- ISBN: 978-9919-21-610-8.



Судлаачид оюутан залуучууд, зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг тууштай хөгжүүлэх зорилт тулгарч байгаа өнөө үед мэргэжлийн чиг баримжаа зүйн ухааны нэр томъёо, ухагдахууны тайлбар толь бичиг уншигчдад ихээхэн хүлээлттэй байгаа билээ. Энэхүү толь бичиг нь ажил мэргэжлийн зөвлөгч, судлаач, бүх шатны сургуулийн багш нар, сурагч, оюутнууд, боловсролын болон хөдөлмөр эрхлэлтийн салбарын ажилтнуудад чухал ач холбогдолтой юм. Үүний зэрэгцээ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд хэрэглэгддэг философи, эрх зүй, улс төр судлал, эрүүл мэндийн шинжлэх ухаан,

техникийн шинжлэх ухаан, мэдээлэл зүйн шинжлэх ухааны 650 гаруй мэргэжлийн нэр томъёонууд тусгагдсан болно.


65.240я2

А 316

/НХУУТ-5/

ЭШФ Б-29396-29400

Болормаа Б., Буяндэлгэр М. **Газар дахин төлөвлөлт** / Ред. П.Мягмарцэрэн, Э.Эрхэмбаяр, Ц.Базарханд.- УБ.: Адмон принт, 2017.- 164х.- ISBN: 978-99978-2-651-0.



Судлаачид энэхүү нэг сэдэвт бүтээлдээ Улаанбаатар хотын газар ашиглалтын байдалд судалгаа хийж, МУ-ын газрын харилцааны нөхцөл байдалд нийцсэн дахин төлөвлөлтийн аргыг шинэчлэн боловсруулах, шийдвэрлэх асуудлыг эрэмблэн тогтоох, Улаанбаатар хотын суурьшлын бүсэд газар дахин төлөвлөлтийн бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлт, загварыг боловсруулах, боломжтой байршлыг тогтоож, бүсчлэлийг зураглан хэтийн чиг хандлагыг тодорхойлон сайжруулах арга зам, санал зөвлөмжийг боловсруулан дэвшүүлсэн байна.

65.32-5

Б 559

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-22880-22882

Граэм Б. **Ухаалаг хөрөнгө оруулагч**: Үнэ цэнийн хөрөнгө оруулалтын гарын авлага / Орч. Э. Амарбаясгалан; Ред. Э.Түвшинбаяр, П.Сарангарав.- УБ.: Монсудар, 2018.- 410х.- ISBN: 978-99973-1-560-1.



Таны санхүүгийн амжилт таны дотор нуугдаж байдаг бөгөөд та өөрийн сахилга бат, эр зоригийг хөгжүүлж чадвал санхүүгийн хувь заяагаа өөрийн гарт атгаж чадах болно. Таны оруулсан хөрөнгө оруулалт хир өгөөж өгөх нь та яаж авирлахаас ихээхэн хамааралтай байдаг хэмээн өгүүлэх Граэмийн энгийн мөртлөө алтан зарчмуудын ач тусыг орчин үеийн жишээн дээр харуулж, шинэ тайлбар нэмсэн энэ сонгодог зохиолыг уншснаар эрхэм уншигч та хувьцаа, бондод хөрөнгө оруулах, ашиг хүртэх, санхүүгийн зорилгодоо хэрхэн хүрэх талаар өргөн мэдлэгтэй болох буй заа.

65.268

Г 621

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-22867-22869

Оюунчимэг Б. **Төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах арга зүй** / Хян. Л.Шагдаррагчаа.- УБ.: ШУТИС-ийн хэвлэлийн газар, 2019.- 98х.- ISBN: 978-99978-68-78-7.



Зохиогч номондоо төсөлд техник-эдийн засгийн иж бүрэн судалгаа, шинжилгээ хийх, баримт бичиг боловсруулах аргачлалыг холбогдох дүрэм журам зааврын шаардлагад нийцүүлэн боловсруулж, улс орны үндэсний эдийн засгийн аль ч салбарын хөрөнгө оруулалтын төсөлд шинжилгээ хийх, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах арга зүйн жишиг загварыг боловсруулан буулгасан байна. Тус бүтээл нь хөрөнгө оруулалтын төслийн техник эдийн засгийн үндэслэл

боловсруулах аргачлал мөн төслийн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох аргачлал гэсэн 2 хэсэг, 7 бүлэгтэй болно.

65.050

О 634

/НХУУТ-3, ОУХНУС-5/

ЭШФ Т-22859-22861

Бизнес хэрхэн хийх вэ: Бизнесийн амжилтад хүргэх зурагт хөтөч / Ж.Симс, Ф.Андэрсон, А.Блэк, Жо.Стэнли-Смит; Орч. Д.Баярхүү; Ред. Д.Хүрэлхүү, В.Уянга, Б.Нэргүй.- УБ.: НЭПКО., 2018.- 351х.- зур.- ISBN: 978-99978-51-73-4.



Ердийн нэг бараа солилцооноос эхлээд баялаг бүтээх урлаг болтлоо хөгжсөн бизнесийн ухааныг ойлгох түүнд суралцахыг хүссэн хэн бүхэнд “компани хэрхэн ажилладаг вэ?, санхүү хэрхэн ажилладаг вэ?, үйлдвэрлэлийг хэрхэн явуулах, борлуулалт ба маркетингийг хийх аргууд”-ын талаар энгийн ойлгомжтой тайлбарласан энэ зурагт лавлах номыг монгол уншигчдын эдийн засгийн боловсрол, танин мэдэхүйн хөтөч болгон орчуулан эмхэтгэж, өргөн бариваа.

65.050

Б 475

/НХУУТ-7, БС-5/

ЭШФ Т-22864-22866

УЛСТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Долгорсүрэн Д. **Олон нийтийн дипломат ажиллагаа** / Диз. Ч.Бямбасаруул.- УБ.: МУИС пресс, 2019.- 199х.- ISBN: 978-9919-21-433-3



Тус бүтээлийг улс төр, олон улсын харилцааны чиглэлээр суралцаж буй тэр дундаа гадаад бодлого, дипломат ажиллагааг сонирхон судалдаг оюутан суралцагчид болон уншигчдад зориулав. Мөн олон орны гадаад бодлогын хэрэгжилт болон ОУХ-нд чухал үүрэг гүйцэтгэж байгаа ОНДА-ны онцлог, илрэл, хэрэгжих явц, ОУХ-нд чухал, шинэ хандлага болж буй шалтгаан болон ОНДА-г судлах онол арга зүйг практик талаас нь үүсэл хөгжлийн чиг хандлагатай нь холбон тайлбарлажээ.

66.4

Д 467

/НХУУТ-7, ГНОФ-10, ОУХНУС-10/

ЭШФ Б-29389-29391

Санжмятав Б. **Монгол улсын эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа:** Хөгжлийн хандлага, загвар, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, өр зээл, тулгамдаж буй асуудлууд.- УБ.: МУИС пресс, 2019.- 344х.- ISBN: 978-9919-21-235-3.



Дэлхийн улс орнуудын эдийн засаг харилцан хамааралтай болж бүс нутгийн интеграцид нэгдэн хөгжиж буй энэ цаг үед зохиолч Монгол улсын геополитик, гео эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн бодлого, улс орны эдийн засаг, гадаад хамтын ажиллагааны олон улсын худалдаа, гадаад хөрөнгө оруулалт, өр зээл зэрэг эдийн засгийн тулгамдсан олон асуудлуудын талаар өөрийн судалгаа, мэдлэг туршлагааа

үндэслэн бичсэн энэхүү судалгааны бүтээлийг тус салбарын бодлого боловсруулагч, эрдэмтэн судлаач багш, оюутнуудад зориулсан байна.

66.4(1)

С 311

/НХУУТ-5, ОУХНУС-5/

ЭШФ Б-29344-29346

Л.Түдэв: **Хүүхэд, залуучуудад өв тэгш хүмүүжил төлөвшүүлье:** Дуртгал, дурсамж / Эмхт. Д.Дашжамц; Хян. Я.Сумъяа.- УБ.: ШУТИС-ийн хэвлэл, 2019.- 381х.- ISBN: 987-9919-21-420-3.



ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН

Гангабаатар Д. **Үндсэн хуулийн эрх зүй:** Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал / Ред. Д. Мөнгөндалай.- 3 дахь хэвл.- УБ.: МУИС пресс, 2019.- 311х.- ISBN: 978-99973-42-78-2.



Үндсэн хуулийн эрх зүйг судлахын тулд үндсэн хуульт ёсны онол, зарчмын үндсээс эхлэн судлах шаардлага үүсдэг учраас зохиогч энэ номондоо үндсэн хуулийн тухай ойлголт, үндсэн хуулийн хөгжил, бүтэц, эх сурвалж, ангилал, эрх зүйн зарчмууд, МУ-ын бүрэн эрхт байдал, засаг захиргаа, төрийн эрх мэдэл, төрийн байгууламж, гүйцэтгэх эрх мэдэл болон шүүх эрх мэдлийн зарчмуудын ухагдахууныг эрдэмтэн судлаачдын бүтээл туурвил болон өөрийн судалгаанд түшиглэн бичиж, хуулийн сургуулийн оюутны сургалт, судалгааны хэрэгцээнд зориулан гаргажээ.

67.400.1

Г 215

/НХУУТ-7, ХЗС-10/

ЭШФ Т-22790-22792

Монгол улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг: Олон улсын симпозиумын илтгэлийн эмхэтгэл / Эрхл. ред. Б.Амарсанаа; Эмхт. Э.Туулайхүү.- УБ.: Удам соёл, 2019.- 252х.- ISBN: 978-99978-770-3-1.



2016 оны 10-р сард болсон "Монгол улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг" олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийг толилуулж байна.

67.404

/ХЗС-5/

ЭШФ Т-22944-22946

М-69

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь: Гарын авлага / Боловс. Д.Наранчимэг, З.Баярчимэг, Д.Баяраа; Хян. Д.Дуламсүрэн, Д.Цэнд-аюуш.- УБ.: Урангар пресс, 2019.- 156х.- (Авлигатай Тэмцэх Газар).



Ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт, сонирхлын зөрчлийг зохицуулах шаардлага, арга механизм, зөрчлийг зохицуулахад удирдлага болон нийтийн албан тушаалтны үүрэг, тавигдах хориглолт, хязгаарлалт, байгууллагын хүлээх үүрэг, зөрчлийн мэдүүлэг, оффшорын асуудлын эрх зүйн зохицуулалт, сонирхлын зөрчлийг зохицуулж буй ОУ-ын туршлага, санаачилга, зөвлөмжүүдийг уг гарын авлагад багтсан байна.

67.408

А 944

/НХУУТ-2/

ЭШФ Т-22888-22889

Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм / Эмхт. Ч.Өнөрбаяр, А.Бямбажаргал.- УБ., 2019.- 542х.- ISBN: 978-99978-4-839-0.



Энэхүү бэсрэг эмхэтгэлд манай улсын үндсэн хуулийн эрх зүйн салбарт хамаарах эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг нэгтгэн энэ салбарт туурвисан зохиол бүтээлүүд, эрдэмтдийн судалгааны ажлыг олон түмэнд таниулах, үндсэн хуулийн эрх зүй судлаачид цаашдын эрдэм шинжилгээний ажилдаа ашиглах боломж бүрдүүлэхийг зорьжээ. Уг эмхэтгэл хоёр хэсгээс бүрдэх бөгөөд тэргүүн бүлэгт “Монголын Үндсэн хуулийн эрх зүйн эрдэмтэд, тэдгээрийн товч танилцуулга, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийг”, хоёрдугаар бүлэгт “Монголын Үндсэн хуулийн эрх зүйн эх сурвалжийн лавлагаа”-г 2018 оны 12 дугаар сарын байдлаар шүүн оруулсан байна.

67.400.1

Ү-823

/ХЗС-5/

ЭШФ Т-22883-22885

Батболд Д. Нийтийн эрх зүй дэх тулгамдсан асуудал / Ред. Д.Солонго.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 236х.- ISBN: 978-99973-976-9-0.



Зохиогч энэ номондоо нийтийн эрх зүй дэх тулгамдсан асуудлыг Үндсэн хууль, захиргааны эрх зүй, нийтийн албаны эрх зүй, эрдэс баялагийн ба орон нутгийн эрх зүйн зангилаа асуудлын хүрээнд тодорхой сэдвүүдээр авч үзсэн төдийгүй мөн захиргааны эрх зүйн хэсэгт нэмэлт сайжруулалт оруулсан хоёр дахь хэвлэлээ хууль зүйн салбарын сургалт, судалгааны хэрэгцээнд зориулжээ.

67.4

Б 332

/НХУУТ-3, ХЗС-6/

ЭШФ Т-22788-22789

Буянхишиг Б. Иргэний эрх зүйн бодлогын хураамж: III дэвтэр: Иргэний процесс: 15 тохиолдол хувилбарын хамт нийт 30 бодлого / Хян. А.Дугармаа.- УБ.: LIA Publ., 2018.- 211х.- ISBN: 978-99978-3-207-8.



Иргэний эрх зүйн хэрэглээ хичээлийн хүрээнд Иргэний хууль, ИХШХШТХ-ийг хослуулан хэрэглэх дасгал бэлтгэх зорилгоор зохиолч өөрийн олон жилийн судалгаа, сургалтын материал, туршлага дээрээ үндэслэн иргэний процесс

болон материаллаг эрх зүйн кэйс, тохиолдлыг цуглуулан эмхэтгэсэн энэ гарын авлагадаа иргэний процессын түгээмэл асуудлыг жишээн дээр авч үзэж, УДШ-ийн ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбарыг ашиглахын зэрэгцээ процессын онолын хүрээнд өөрийн багш нарын бүтээлээс тусгажээ.

67.404я7

Б 81

/НХУУТ-3, ХЗС-20/

ЭШФ Т-22786-22787

ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Алтангэрэл Ч. **Баруун ба баруун өмнөд хязгаарт болсон дайн** / Ред. А.Бямбажаргал, Г.Пушкин; Зөвл. О.Пүрэв, Х.Лхагвасүрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2018.

Энэхүү номонд эх орныхоо төлөө эрэлхэгээр тулалдсан хэдэн мянган эх орончдынхоо алдрыг үеийн үед дуурсгаж, гэгээн дурсгалыг нь мөнхжүүлэн, тасарсан түүхийг нөхөж, мартагдсан эх орончдынхоо үнэн түүхийг ямар нэгэн байдлаар сэргээснээр бараг нээлт болох юм. Энэхүү бүтээл нь хожмын судлаач, эх орончдод ихэд тус болж, дайн, тулалдааны хүнд бэрхийг үүрсэн эх орончдын минь үр хойчсынх нь мөнхөд хайрлах гэгээн судар болно гэдэгт итгэж байна.

68.49(1)

А 486

Б.1. Эзэмшил, Эзэрхийлэл,Тэмцэл, Шийдэл / - 332х.-

ISBN: 978-99978-3-353-2.

ЭШФ Б-29378-29379

Б.2. Дайн байлдаан, үйл явдал, шийдвэр.- 340х.-

ISBN: 978-99978-3-352-5

ЭШФ Б-29380-29381

Б.3. Бүү март! Дурдатгал, дурсамж үгүүлэл.- 816х.-

ISBN: 978-99978-3-351-8.

ЭШФ Б-29382-29383



Цогту Огонуус (Акира Оно). **Төвөдөд эргүүлсэн япон сэлэм: Өвөр монголын морьт цэрэг** / Орч. Д.Пүрэвдэлгэр, Х.Арслан; Орч. Ред. С.Ганбат; Ред. Ш.Баярмагнай, Б.Сарангарав.- УБ.: Монсудар, 2014.- 443х.- ISBN: 978-99973-1-647-9.

Өвөр Монголын Ордос нутгийн хүү Акира Оно буюу Огнос Цогтын түүх нийгмийн судалгааны чиглэлээр бичсэн олон арван бүтээл байдгаас онцлон сонгож, орчуулан монгол уншигчдад хүргэж байгаа энэ бүтээлд зохиолч Монгол үндэстний XX зууны түүхэн явдлуудыг өгүүлэхдээ Монголчуудын мөн чанар, үнэт зүйлсийг тод томруун тусгахыг зорьжээ. XX зууны дунд үе гэхэд ар, өвөр монголчууд аль аль нь цэрэг зэвсэг, байлдах чадварын хувьд хамгийн өндөр түвшиндээ хүрсэн боловч тэрхүү давуу байдлаа ашиглаж чадаагүй харамсалтай түүхийг баримттайгаар өгүүлэхийн зэрэгцээ япон сэлэм болон морьтон монгол цэргийн оролцоотойгоор Төвөд, Монголын ээдрээтэй



бараан түүхийн хоосон орон зайг нөхөж чадваас энэ бүтээлийн үнэ цэнэ орших болно хэмээн зохиолч өгүүлжээ.

68.49(545)

Ц 756

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Б-29330-29332

ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ

Чулуунбаатар Г., Мөнхцэцэг Б. **Шинжлэх ухааны танин мэдэхүйн логик, судалгааны ажлын арга зүй**: Магистрантур, докторантурын сургалтанд зориулсан гарын авлага / Ред. Г.Сүхбат, Д.Мандах, Ц.Цэцэнбилэг.- УБ.: Мөрөөдлийн гурвалжин, 2017.- 240х.- ISBN: 978-99978-0-502-7.



Эл бүтээлийг зохиогчид нь өмнөх бүтээлээ бүхэлд нь шинэчлэн найруулсан төдийгүй сүүлийн үеийн судалгааны ажлын үр дүн, ном бүтээлийг өргөн ашиглан баяжуулсан энэхүү гарын авлагад шинжлэх ухааны мэдлэг, түүний бүтэц, бүрэлдэж буй логик, шинжлэх ухааны танин мэдэхүйн нэн чухал түгээмэл зарчмууд, баримт мэдээлэлийн логик үндэслэл, нотолгоо зэргийг багтаасан онол, арга зүйн ерөнхий шаардлага болон судалгааны ажил хийхэд төлөвлөгөө концепц боловсруулахаас эхлээд судалгаа хийх, цэгцлэх, илтгэл өгүүлэл бичих, тэдгээрт өөрийн санаа дүгнэлт, үзэл бодлоо томъёолох хүртлэх процессод туслах нэн чухал аргачлалыг багтаасан байна.

72

Ч 891

/НХУУТ-5/

ЭШФ Б-29316-29320

Кумар Р. **Судалгааны арга зүй = Research methodology**: Чанартай судалгаанд алхам алхмаар чиглүүлэх хөтөч / Ерөн. ред. М.Батчимэг; Орч. О.Лхагвасүрэн, Д.Чулуунцэцэг.- 4 дэх хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 434х.- ISBN: 978-99978-806-5-9.



Энэхүү номонд Судалгааны загварын концепцийг тогтох, асуудал томъёолох, төсөл бичих, таамаглал дэвшүүлэх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, танилцуулах, тайлан бичих, төсөл бичих, Хандлагын шкал ашиглан мэдээлэл цуглуулах гэх мэт судалгааны арга зүйн талаар өгүүлжээ.

72

К 909

/ОУХНУС-5, НХУУТ-2/

ЭШФ Т-22927-22928

Солонгос судлал: Эрдэм шинжилгээний сэтгүүл 2019 №2(6), / Эрхл. Ц.Цэрэндорж.- УБ.: МУИС пресс, 2019.- 132х.- ISBN: 978-99978-3-225-2.



Энэ дугаарт Өмнөд Солонгос улсын түүх, соёл, солонгос хэл шинжлэл, Корйё улсын вангаас Монголын их хаанд илгээсэн өргөх бичигтэй холбогдолтой судалгааны 10 гаруй өгүүлэл оржээ.

72(5Сол)я5

/ЛавФ-1/

ЭШФ Т-22941-22943

С 556

Лавай №22: Эрдэм шинжилгээний бичиг (Vol. 15) / Эрхл. Я.Шийлэгмаа.- УБ.: EDU пресс, 2019.- 256х.- (Монгол Улсын Боловсролын Их Сургууль).- ISSN 2410-4507.



МУБИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэлийн энэ дугаарт сургалтын технологи, БНСУ, Хятад улсын боловсрол, гадаад болон эх хэл соёл судлалын чиглэлийн 30 гаруй судалгааны өгүүлэл оржээ.

72

Э-739

ЭШФ Т-22929-22930

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Ажил, мэргэжлийн хөтөч: Job guide: Гарын авлага / М. Батбаатар, Н. Болдмаа, Д. Бумдарь ба бус.; Ред. Д.Гомбо.- УБ.: Удам соёл, 2019.- 469х.



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн чадавхтай боловсон хүчнийг бэлтгэх зорилтын хүрээнд МУИС, ХБНГУ-ын Хөдөлмөрийн дээд сургуультай хамтран ажил мэргэжлийн зөвлөгч бэлтгэх мэргэжлийн магистрын хөтөлбөрийг 2017-2018 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн билээ. Энэ ном нь ЕБС-ийн сурагчид, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч, магистрын сурагчид, одоогоор зөвлөгөө өгч байгаа практик зөвлөгч нар, боловсролын болон хөдөлмөр эрхлэлтийн салбарын ажилтнууд, ажил олгогч байгууллагуудын хүний нөөцийн менежерүүдэд чухал ач холбогдолтой бүтээл юм.

74.200.52

А 316

/НХУУТ-5/

ЭШФ Т-22967-22971

Ажил мэргэжил судлал: Онол, арга зүй, аргачлал / М. Батбаатар, Н. Болдмаа, Д. Бумдарь ба бус.; Ред. С.Мөнхбат, Б.Болд-Эрдэнэ; Зөвл. Б.Туяа.- УБ.: Пресс Лоорд, 2019.- 242х.- ISBN: 978-9919-21-708-2.



Энэхүү сурах бичиг нь ажил мэргэжил судлалын онол, арга зүй, мэргэжил сонголт, ажил мэргэжлийн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөний арга техник, хөдөлмөрийн зах зээл, эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн кейс, менежмент, хүний нөөцийн удирдлага, нийгмийн сүлжээ, маркетингийн онол, практикийн асуудлыг цогцоор боловсруулсан, ажил мэргэжлийн зөвлөгч, судлаач, бүх шатны сургуулийн багш нар, боловсролын болон хөдөлмөр эрхлэлтийн салбарын ажилтнуудад гарын авлага болох чухал ач холбогдолтой юм.


74.58+65.240

А 316

/НХУУТ-5/

ЭШФ Т-22962-22966

Лхасүрэн Б. ба бус. **Боловсролын нэр томъёоны англи-монгол толь:** 2000 орчим толгой үгтэй / М. Булганцэцэг, Л. Энхбаяр; Хян. Б.Жадамба.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 164х.- (Монгол Улсын Боловсролын Их Сургууль. МУБИС-ийн Эрдэм Шинжилгээний албаны төсөл).- ISBN: 978-9919-21-105-9.



Боловсролын нэр томъёоны чиглэлийн 2000 орчим толгой үгийг багтаасан энэ толь бичиг нь тухайн салбарын судлаачдад боловсролын онол, үзэл баримтлал, ухагдахууныг зөв орчуулж, ойлгоход тус болох бөгөөд төслийн багийнхан уг толь бичгийг бүтээхдээ Оксфордын Их Сургуулийн хэвлэлийн газраас 2009,2015 онд хэвлэсэн Сюзан Уолисийн толийг зонхилон ашиглаж, нэр томъёоны тайлбарыг хийсэн байна. Мөн Америк сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийн нэр томъёог загвар хөтөлбөртэй нь англи эхээр хавсаргажээ.

74я2

Л 874.

/НХУУТ-5, ГНОФ-5/ ЭШФ Б-29339-29341

Урлаг судлалын боловсролын гарын авлага = SHARE, Handbook for artistic research education / Орч. Б.Баяраа, Д.Цэдэвсүрэн; Хян. Д.Даваасүрэн, Э.Сонинтогос, Д.Цэдэвсүрэн.- УБ.: Сэлэнгэпресс ХХК, 2016.- 370х.- (Монгол Улс. Соёл Урлагийн Их Сургууль).- ISBN: 978-99978-4-300-5



Энэ ном нь SHARE сүлжээний гурван жилийн ажлын тайлан бөгөөд тус холбоо нь Европ дахь 3 дахь шатны урлаг судлал ба боловсролын хөгжлийг дэмждэг ОУ-ын байгууллага юм. Уг гарын авлагад урлаг судлалын боловсролыг хэрхэн системтэй зохион байгуулахтай холбоотой аргачлалыг 5 хэсэг, 12 бүлэг, 51 дэд хэсэгтэйгээр өргөн хүрээнд олон жишээ баримтаар өгүүлж, тусгасан нь өнөөдөр манай улсад маргааны талбар болж буй “ урлаг судлал, уран бүтээлд суурилсан доктор”-ын тухай хэлэлцүүлгийг өнөөгийн туршлага, практикт тулгуурлан хэрхэн үргэлжлүүлэх талаар дэлгэрэнгүй уншиж, эрэгцүүлэх боломжтой.

74.58

У 491.

/НХУУТ-2/

ЭШФ Б-29394-29395

СЭТГҮҮЛ ЗҮЙ. НОМ СУДЛАЛ

Зулькафиль М. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд: Б. 11: **Ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүйн онол, практикийн асуудлууд** / Ред. Б.Болд-эрдэнэ, Б.Наранбаатар.- УБ.:Удам соёл, 2019.- 300х.- ISBN: 978-99978-872-7-6.



Орчин үеийн сэтгүүл зүйн онол, практик, арга зүйн олон чухал асуудлыг багтаасан энэхүү гарын авлагын эхний бүлэгт чөлөөт хэвлэлийн мөн чанар, сэтгүүлчийн ёс зүй, америкийн чөлөөт хэвлэлийн тогтолцоо, зөвлөлтийн коммунист онолын үзэл баримтлал, дэд бүлэгт Монголд 1990 оноос хойш нэвтэрсэн эрэн сурвалжлах сэтгүүл зүй, цахим сэтгүүл зүйн өнөөгийн байдал, гутгаар бүлэгт теле сэтгүүл зүй болон монгол сэтгүүл зүйн хөгжилд “Үнэн” сонины гүйцэтгэсэн үүрэг, төгсгөлийн бүлэгт сэтгүүл зүйн онолын судлагдахууны асуудал зэрэг агуулгыг багтаасан байна.

76.01

3-80

/НХУУТ-8, ГНОФ-5/

ЭШФ Б-29333-29335

Сэтгүүлчийн ур чадвар: Түүх, онол, практик: Цуврал 3 / Ерөн. ред. М.Зулькафиль; Ред. Г.Мэндхүү.- УБ.: Удам соёл, 2019.- 200х. ISBN: 999788726-3



Энэхүү цувралын эхний хоёр номыг интернэт сэтгүүл зүй, телесэтгүүл зүйн түүх, онол практикийн асуудлаар гаргасан бол гурав дахь номыг сэтгүүл зүйн онол, практикийн асуудлаар бэлтгэн уншигчдад хүргэж байна. Уг бүтээлд Монголын сэтгүүл зүйн ахмад болон шинэ үеийн шилдэг сэтгүүлчдийн уран бүтээлүүдийн ур чадварт хийсэн ажиглалт, дүгнэлт, тэдний нийтлэлүүдийн онцлог шинж, шинэлэг хандлага, үнэлэлт дүгнэлтийг тусгаснаараа онцлог юм.

76.01

С 972

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-2022857-2022858

Цэнджав Д. Монголын шилдэг нийтлэл: Цувр. 69: Эргэх цагийн хүрдэн / Ерөн. ред. Т.Баасансүрэн; Зөвл. Л. Түдэв, Ц.Дашдондов, Б.Лигдэн; Хян. Б.Баянжавзан.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 672х.- ISBN: 99973-2-329-7.



Сэтгүүлчийн хөдөлмөрт чинээндээ тултал нухлуулсан сэхээтэн гэгддэг зохиолч, сэтгүүлч Д.Цэнджавын монголын нийгэм улс төрийн амьдрал болоод монгол хүмүүний тухай, урлаг соёл, сэтгүүл зүйн тухай гэх мэт олон чиглэлээр бичсэн өгүүлэл, нийтлэл, ярилцлага, сурвалжилсан тэмдэглэл, аян замын найруулал, тэмдэглэл, мэргэжил нэгтнээ шинжин тольдсон сэтгүүл зүй судлалын өгүүлэлүүд, шилмэл эсээнүүд нь энэ номонд оржээ.

76.01

Ц 956

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Б-29370-29372

Цаасан өвийн гэмтэл, сэргээн засварлалт / Д.Энхтунгалаг, Б.Отгонтуяа, Б.Тунгалаг, Г.Ням-Очир; Ред. Д.Энхтунгалаг.- УБ.: Голден легион, 2017.- 126х.- ISBN: 978-99978-0-239-2.



Монгол улсын үндэсний номын сангаас эрхлэн хэвлүүлж буй тус бүтээлд аливаа улс орны түүхийн чухал баримтат өв болох цаасан өвийн хадгалалт, хамгаалалт болон сэргээн засварлах практик аргачлалыг дэс дараатай, зураг тайлбартайгаар толилуулжээ. Сэргээн засварлалтын бодит ажлыг дэлгэн харуулсан эл ном нь тус салбарын мэргэжилтнүүдэд чухал зөвлөмж бүхий гарын авлага болсон байна.

78.36


Ц 106

/НХУУТ-3/

ЭШФ Т-22832-22834

Баттөгс Ш. Хурдан уншиж, ойлгох чадвараа хөгжүүлэх нь: Уншиж, ойлгох чадвараа хөгжүүлэх сурах бичиг: Бүх шатныханд зориулав / Хян. А.Цог-Очир.- УБ.: Битпресс 2019.- 192х.- ISBN: 978-999-78-68-91-6.

Энэ номонд зохиогч уншигч түмний танин мэдэхүйн санд хэрэг болохуйц гэж үзсэн уран сайхны, адал явдалт, шинжлэх ухаан, танин мэдэхүйн, нийгэм соёлын, шашны холбогдолтой 21 шилдэг эсээ, бичвэрийг сонгон авч, тэдгээрт



тохирсон асуулт даалгавар, унших арга зүйн зөвлөмжийн хамт оруулжээ. Тус ном нь уншигч танд унших сэдвээ сонгох, унших арга техник эзэмших, зорилготой, үр дүнтэй уншиж сурахад туслах болно.


78.303

Б 341

/НХУУТ-7/

ЭШФ Т-22826-22828

Шинковой А.И. **Монгол болон дорно дахины бурханы шашны өв: XVII-XX зуун = Буддийское наследие Монголии и востока: XVII-XXвв.:** Эрхүүгийн тойргийн орон нутаг судлах музейн дорно дахины цуглуулгын судалгаа ба эд өлгийн цомог / Ред. С.Чулуун, Э.Сонинтогос, Г.Д. Лопатовская; Орч. Н.Ганбат.- УБ.: 2018,- 464х.- Зур.- ISBN: 978-99978-733-7-8.



Музейн үүсэл хөгжлийн тухай тойм тэмдэглэлийг цуглуулагч нарын талаархи мэдээ сэлтээр баяжуулсан тус гэрэл зургийн цомогт музейн түүхэнд анхдагч болох ОХУ-ын Сибирийн музейн түүх болон Хятад, Монгол, Өвөр Монгол, Төвөд, Балба, Япон зэрэг оронд хийгдсэн судалгааны бүтээл, лавлах материалуудаас багтжээ.

79.1я6

Ш 65

ЭШФ Т-22872-22873

ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Том Полсон. **IELTS-ийн шалгалтанд бэлтгэх заавар:** Хурдан бэлтгэл, өндөр оноо: Сонсгол, уншлага, бичиг, яриа / Орч. Т.Долгор.- УБ.: Адмон, 2016.- 47х.- ISBN: 978-99973-0-927-3.



Зохиогч энэ номондоо IELTS-ийн шалгалт өгсөн хүмүүсийн гаргадаг түгээмэл алдааг нягтлан дүгнээд, шалгалтыг амжилттай өгөхөд туслах хамгийн шилдэг аргуудыг боловсруулж эмхэтгэн уншигч танд хүргэж байна. Энэхүү гарын авлага нь заавар зөвлөгөө гэхээсээ илүү IELTS-ийн шалгалтын өөрийнх нь сул талыг олж харах, түүн дээр тоглолт хийх, шалгалт өгч буй хүмүүсийн гаргадаг хамгийн нийтлэг алдааг давтахаас тань сэргийлэхэд туслах зорилготой тактикийн зэвсэг юм.

81.2Англ

Т 48

ЭШФ Б-29392-29393

Дэмчигмаа О. **Уламжлалт анагаах ухааны төвөд хэл сурах бичиг /** Ариутган шүүсэн Д.Бүрнээ.- УБ.: Удам соёл, 2017.- 156х.- ISBN: 978-99978-2-748-7.



Дорнын анагаах ухааны ач тусыг хүмүүс ойлгон сайшаах болсон өнөө үед сургалт судалгааны болоод сонирхогчийн түвшинд төвөд хэл сурах хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа билээ. Тиймээс зохиогч уламжлалт анагаах ухааны үг хэллэг бүхий төвөд хэл бичгийг хялбар сурах энэхүү сурах бичгийг өөрийн

олж мэдсэн, цуглуулсан баримт судалгаандаа тулгуурлан бичиж эмхлэн, төвөд хэл сонирхон судлахыг хүссэн хүн бүхэнд зориулан өргөн барьжээ.

81.2Төвд-923

Д 905

/НХУУТ-5/

ЭШФ Т-22821-22825

Дэмчигмаа О. "Субашид"-ын монгол орчуулгуудын галиг, үгсийн хэлхээ / Ариутган шүүсэн Ц.Шагдарсүрэн.- УБ.: Удам соёл, 2013.- 721х.- ISBN: 978-99962-72-82-0.



Судлаач энэ бүтээлдээ "Субашид" зохиолын найман орчуулгын хамгийн эртнийх буюу Сономгараагийн орчуулгыг үгийн сангийн үүднээс судлахдаа бусад орчуулгуудтай харьцуулан, гадаад дотоодын олон эрдэмтний холбогдох судалгааг харгалзан үзсэн ба эхийг эрдэм шинжилгээний роман буюу латин үсгээр галигласан, эхийн зураг хийгээд үгийн хэлхээг хавсаргасан зэргээрээ тус бүтээл нь монгол орчуулгын судлалд нөлөө бүхий цогц бүтээл болжээ.

81.2М-7

Д 336

/НХУУТ-4/

ЭШФ Т-22813-22816

Дэмчигмаа О. "Субашид"-ын монгол орчуулгуудын үгийн сангийн онцлог / Ариутган шүүсэн Ц.Шагдарсүрэн.- УБ.: Удам соёл, 2013.- 207х.- ISBN: 978-99962-72-82-0.



Судлаач энэ бүтээлдээ түүвэрлэн сонгож авсан үгсээ зургаан орчуулгын хүрээнд жишээ баримтаар нутлан тайлбарлаж, эртнээс эдүгээ хүртэл, утга хэрэглээ нь хэрхэн хувьсч өөрчлөгдснийг авч үзсэн байна.

81.2М-7

Д 336

/НХУУТ-4/

ЭШФ Т-22817-22820

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Бүрэнбэх Б. Монгол шүлгийн гоо зүйн түүхчилсэн төлөв: Эрдэм шинжилгээний цуврал Б.1: Хятад дахь монгол судлалын шилдэг бүтээлүүд / Ред. С.Байгалсайхан, Д.Цэдэв, Х.Сүглэгмаа.- УБ.: Жиком пресс, 2017.- 272х.- ISBN: 978-99978-843-1-4.



Энэхүү бүтээл нь Монгол судлал болон утга зохиол судлалд нэн хэрэгтэй бүтээл болж байна. Эртний Монгол шүлгийн уламжлалыг Монгол ардын баатарлаг туульсуудаар дамжуулан аман бичгийн уран зохиолын харилцан хамаарлын дунд авч ирээд зогсохгүй, Хасбуу, Инжинаш зэрэг олон найрагчдын жишээн дээр тайлбарласан бүтээл юм.

83.3(1)

Б 878

ЭШФ Б-29376-29377

УРАН ЗОХИОЛ

Бадраа С. **Билгийн чуулган:** / Эрхл. Х.Зандраабайдий; Эмхт. З.Анхзаяа, Ч.Пүрэвдорж; Зөвл. Ш.Энхбаяр.- УБ.: Жиком пресс, 2019.

Зохиолч, сэтгүүлч орчуулагч Самбуугийн Бадраагийн мэндэлсний 95 жилийн ойд зориулан гаргаж буй энэ бүтээлийн чуулганд түүний бүтээлийг тэмдэглэл, найруулал, өгүүллэг, туужаар нь ангилан эмхэтгэж мөн орчуулгын бүтээлийнх нь дээж болгон М.Шолоховын “Дон” өгүүллэгээс нь оруулжээ.

84(1)-44

Б 159

Б. 1. Тэмдэглэл, найруулал, өгүүллэг.- 400х.-


ISBN: 978-99978-60-57-

ЭШФ Б-29312

Б. 2: Тууж, орчуулга.- 388х.-

ISBN: 978-99978-60-58-3.

ЭШФ Б-29313



Урианхай Д. **Зохиолын эмхэтгэлийн эхний 10 боть** / Ред. Г.Ариунчимэг, Д.Гүнболд.-УБ.: Тоонотпринт, 2018.- (Улаан ямаат Урианхай судлал академи).

Их зохиолчийн энэхүү 10 боть зохиолын эмхэтгэлд түүний уран бүтээлийн чимхлүүр эрэл хийж, оюунаа чилээн туурвисан яруу сайхан шүлэг найргийн бүтээлүүд, хүмүүний амьдралын алдаа оноог тунгаан болгоосон утга уянгатай тууж, романууд нь багтсан байна. Төгсгөлд нь Д. Урианхайн уран бүтээлд бусад судлаачдын өгсөн үнэлэлт, дүгнэлт, шүүмж судлалын өгүүлэлүүдийг оруулжээ.

84(1)

У 486

Б. 1. Яруу найраг- I: Цагийн хөл, Цээжний нөмөр, Насны хишиг, Дотоод чинад, Үгийн сүү.- 591х.- ISBN: 978-99978-813-0-4.

/НХУУТ-2/

ЭШФ Б-29347-29348

Б.2. Яруу найраг- II: Нялх хөлийн салхи, Үгүйлэхийн халуун-I, Огтлолцохуй-I, Холдох төв, Үгүйлэхийн халуун-II, "У" гараг буюу Огтлолцохуй-II.- 543х.- ISBN: 978-99978-813-2-8.

/НХУУТ-2/

ЭШФ Б-29349-29350

Б.3. Жүжиг- I: Жүжгүүд-1, Тайз дэлгэцийн контемпорари бүтээлүүд.- 487х.- ISBN: 978-99978-813-1-1.

/НХУУТ-2/

ЭШФ Б-29351-29352

Б.4. Жүжиг- II: Жүжгүүд-1: Тайз дэлгэцийн контемпорари бүтээлүүд.- 483х.- ISBN: 978-99978-813-4-2.

/НХУУТ-2/


ЭШФ Б-29353-29354

Б.5. Тууж- I: Таны шинэ танил, Зүүд ба улаан нулимс, Өвлийн шувуу, Гүйгээд л хүрчихмээр ойрхон санагдах манант цамрын үзэгдэхгүй орой.- 487х.- ISBN: 978-99978-813-3-5.

/НХУУТ-2/

ЭШФ Б-29355-29356

Б.6. Тууж- II: Монголчууд...бүгдийн танилууд бүгдээрээ нэгэн амралтанд, Зааг буюу бид та тэд, Ойн “сонат”.- 479х.- ISBN: 978-99978-813-5-9.



- /НХУУТ-2/ ЭШФ Б-29357-29358
- Б.7. Өгүүллэг:** Тэнгэр тэмдэгрэх, Тэрэлжийн өдрүүд... намар оройн хараацай, Тугалын зүүд.- 407х.- ISBN: 978-99978-813-6-6.
- /НХУУТ-2/ ЭШФ Б-29359-29360
- Б.8. Эсээ-Бодрол:** Өвгөн үг, Хүн танаа, Өвлийн шувуу, Дуугүй ном, Цээжин аглагийн шүүдэр буюу голын эргээс эргүүлэг рүү нь, Хүн танаа шүүмж.- 383х.- ISBN: 978-99978-813-7-3.
- /НХУУТ-2/ ЭШФ Б-29361-29362
- Б.9. Роман- I:** Халуун зуны сүүдэр: Бэсрэг роман.- 255х.- ISBN: 978-99978-813-8-0.
- /НХУУТ-2/ ЭШФ Б-29363-29364
- Б.10. Роман- II:** Учрахуй, хагацахуй.- 512х.- ISBN: 978-99978-813-9-7.
- /НХУУТ-2/ ЭШФ Б-29365-29366

Ядмаа Н. **Одонтой тэнгэр** / Хян. Н.Пүрэв.- УБ.: Сэлэнгэпресс, 2018.- 724х.- ISBN: 978-99978-3-345-7.

Ахмад зохиолчийн шилмэл бүтээлийн түүвэрт цэцэрлэгийн болон бага, дунд сургуулийн хүүхдэд зориулсан үлгэр, эсээ өгүүллэг, тууж, найраглал, шүлэг, хөрөг, дурсамжууд нь орсон байна.

84(1)-4

Я 368




ЭШФ Б-29314-29315

Монголдын күпия шежіресі Монғолша тандаулы нұсқасының қазақ тіліндегі аудармасы қосымша түсініктемесімен бірге: Монголын нууц товчооны сонгомол эхийн казах хэл дээрх орчуулга нэмэлт тайлбарын хамт / Орч. Т.Етекбай; Ред. М. Курметхан, М.Ууганбаяр.- УБ.: Бэмби сан, 2019.- 218х.- ISBN: 978-99978-990-0-2.

Энэхүү бүтээлд Монголын нууц товчооны сонгомол эхийг казах хэл дээр орчуулан, нэмэлт тайлбар хийж, эмхэтгэн хэвлүүлсэн байна.

84(1)

М 77



ЭШФ Б-29387-29388

Кафка Ф. **Шүүх ажиллагаа:** Роман / Орч. Б.Ундрах; Хян. Г.Сугиррагчаа, Ш.Баярмагнай, П.Сарангарав.- УБ.: Монсудар, 2019.- 348х.- (Орчин үеийн уран зохиол №27).- ISBN: 978-99973-1-677-6

XX зууны герман хэлт зохиолчдын хамгийн том төлөөлөл болсон Франц Кафкагийн энэ зохиолын гол баатар Иозеф К. яг гучин насныхаа төрсөн өдрөөр хийгээгүй хэрэгтээ хилсээр гүтгүүлэн баривчлагдаж байгаагаар зохиол эхлэнэ. Иозеф К. нь нэгэн банканд том албан тушаалд ажилладаг бөгөөд хачирхалтай нь түүнийг цагдан хорихгүй, хамт ажилладаг хүмүүсээр нь дэргэдээс нь хянах замаар мөрдөж мөшгөхөөр гурван ажилтанг түүний дэргэд байлгана. Үйл явдал цааш хөвөрсөөр Иозеф К. нь өөрийгөө буруугүй гэдэгтээ эргэлзэх болж хүчгүй дорой болохоо улам



ихээр мэдэрнэ. Зохиолын үйл явдал цааш хэрхэн өрнөхийг эрхэм уншигч та энэ номноос амтархан уншина уу.

84(4Чех)-44

К 30

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29327-29329

Шукшин В.М. **Хачин хүмүүс** / Ред. Н.Нансалмаа.- УБ.: МУИС пресс, 2019.- 130х.- ISBN: 978-99978-4-659-4.



Уншигч танд танилцуулж буй уг номонд ХХ зууны Оросын уран зохиолын нэрт төлөөлөгч В.М. Шукшины бүтээлээс 16 өгүүллэгийг түүвэрлэн орчуулж анх удаа монгол хэлээр хэвлэсэн байна. Өгүүллэгийн баатрууд нь орос хүний араншинг олон талаас нь харуулж буй энгийн хүмүүс боловч, нөгөө талаас хачин бүтэлгүй, мөрдөгчид, тэмцэгчид бөгөөд тэднийг зохиолч “хачин хүмүүс” гэж нэгтгэн тодорхойлжээ.

84(2Рус)-44

Ш 903

ЭШФ Б-29321-29323

Лү Шюний нэрэмжит утга зохиолын VII удаагийн шагналт бүтээлүүд / Ерөн. ред. Ц.Улаантуяа; Хян. Б.Мөнхбаяр, Г.Буянтогтох.- Өвөр Монгол Виндзор, 2019.- (БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Утга Урлагийнхны Холбоо).



БНХАУ байгуулагдсан болон БНХАУ, Монгол улстай дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулан, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Утга Урлагийнхны Холбоо удирдан, Өвөр Монголын Орчуулагчдын эвлэлээс эрхлэн Лү Шюний нэрэмжит утга зохиолын 7 дахь удаагийн шагналт бүтээлийн сонгомолын цуврал 4 дэвтэрийг толилуулж байна. Тус бүтээлд утга зохиолын салбарын шагналт зохиолч, орчуулагч нарын цаг эриний өөрчлөлт, хүн ардын үзэл бодол, зан заншил, хувь тавилангийн эргэлтийг амьд мэт дүрслэн харуулсан эсээ найруулал, хөрөг найруулал, тууж, өгүүллэг, яруу найргийн шилдэг бүтээлүүд нь багтжээ.

84(5Хят)

Л 86

Б.1: Эсээ найрууллын боть.- 289х.- ISBN: 979-9919-21-966-6.

/НХУУТ-3/

ЭШФ Т-22953-22954

Б.2: Хөрөг найрууллын боть.- 561х.- ISBN: 978-9919-21-968-0.

/НХУУТ-3/

ЭШФ Т-22955-22956

Б.3: Тууж, өгүүллэгийн боть.- 583х.- ISBN: 978-9919-21-967-3.


/НХУУТ-3/

ЭШФ Т-22957-22958

Б.4: Яруу найргийн боть.- 146х.- ISBN: 978-9919-21-965-9.

/НХУУТ-3/

ЭШФ Т-22959-22960



Лю Цы Синь. **Гурван биет** / Хян. С.Туяагэрэл; Орч. Д.Болдбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2019.

Дэлхийн олон хэл дээр хэвлэгдсэн энэхүү уран зөгнөлт зохиол нь сансар огторгуйн далд нууцыг хүн төрөлхтний үүсэл хөгжлийн олон мянган жилийн түүхтэй нягт сүлжилдүүлэн урлаж бичсэн агаад уг номонд Хямралтай эриний гуравдугаар онд Гурван биет ертөнцийн сансрын флот нарны аймгаас 4.21 гэрлийн жилийн зайд буй, наймдугаар онд 4.20 гэрлийн жилийн зайд буй, 205 дугаар онд 2.10 гэрлийн жилийн зайд байх тухай дэлхийн хүчний талаар онц сонирхолтой өгүүлжээ.

- Б.1: Гариг дэлхийн өнийн хэрэг.**- 368х.- ISBN: 978-99978-924-5-4.
/НХУУТ-2/ ЭШФ Т-22947-22948
- Б.2: Балар ой.**- 600х.- ISBN: 978-99978-924-6-1.
/НХУУТ-2/ ЭШФ Т-22949-22950
- Б.3: Эрлэгийн мөнхрөл.**- 704х.- ISBN: 978-99978-924-7-8.
/НХУУТ-2/ ЭШФ Т-22951-22952



Оюунжаргал Р. **Хуучин байшингийн цэнхэр нүдэн**: Баримтат уран сайхны зохиол / Ред. Д.Ичинхорлоо.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 124х.- ISBN: 978-99978-4-884-0.

Энэ номонд зохиолч өөрийн хүүхэд насны гэнэн явдал, гэгээн өдрүүдийнхээ тухай дурсамжаа өгүүлэн буулгажээ. Үйл явдал 1973 оны зунаас 1974 оны хавар хүртэл нэг жилийн дөрвөн улиралд хугацаанд юу юу хийж бужигнуулж явснаа, өвөө эмээдээ магтуулж, зэмлүүлж, бүр зодуулж явсан тухай тус номонд гардаг.

84(1)-5

О-634

ЭШФ Т-22807-22809



УРЛАГ СУДЛАЛ

Батхуяг П. **Цаг хугацаа, орон зайн хэл**: Эсээ шинжлэл / Ерөн. ред. О.Содномпил.- УБ.: Жиком пресс, 2019.- 170х.- (Утга зохиолын судлал шинжлэл: Цувр. 29).- ISBN: 978-99978-60-69-9.

“Утга зохиолын судлал шинжлэл” цуврал хэвлэлийн энэ дугаарт судлаач, шүүмжлэгч П.Батхуягын Монголын кино, жүжгийн урлагийн өнөөгийн байдалд мэргэжлийн судлаачийн үүднээс хандаж, задлан шинжилж, үнэлж цэгнэсэн, шинэ бодомж тээсэн шүүмж эсээнүүд нь орсон. Эдгээр эсээнүүд нь манай театр, дэлгэцийн урлагийн уран бүтээлчдэд хандан бүтээсэн, бүтээж буй, бүтээх гэж буй бүтээл туурвилаа өөр өнцгөөс харж, өөрчлөгдөх хэрэгтэйг сануулсан ажээ.

85.3

Б 342.

/НХУУТ-4/

ЭШФ Б-29373-29375



Монголын урлаг судлаачдын форум-I: Эмхэтгэл / Эмхт. СУИС-ийн СУСХ-ийн Урлаг судлалын сектор; Ред. Д.Энхцэцэг.- УБ.: Бэмби сан, 2018.- 168х.- (БСШУСЯ. МУ-ын СУИС).- ISBN: 978-99978-749-0-0.



Урлаг судлал-Орчин үе” төслийн хүрээнд зохион байгуулсан форумд оролцсон судлаачдын урлаг судлал, шүүмжээр дагнан хэлэлцүүлсэн илтгэлүүд, урлаг судлаачдын дугуй ширээний ярилцлага, нийтлэл, шүүмжийг энэ эмхэтгэлд оруулжээ.

85(1)

М 695

/НХУУТ-4/

ЭШФ Т-22847-22849

Энхдаваа Д. **Түмэн хээ.**- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 599х.- зур.- Б.1.- ISBN: 976-99978-3-362- 4.



Энэхүү номноос эрхэм уншигч та монгол хээний ай сав, анги, төрөл, садан хээ, тэдний түүхэн өвийн тодорхой ул мөр, мөн түүний хөгжлийн үечлэл, хураан судлах гурван аймаг, хээний түмэн чуулган цоморлогтой танилцах болно. Хээ угалзны зурлага дүрслэл, дэг тигийг тодруулахын зэрэгцээ түмэн хээний өвийг, тэнгэрлэг гоо зүйн баялгаар нь, давтагдашгүй сэдэл донж төрхөөр нь, зохиомжийн олон талт дүрслэлийн тогтолцоог онцлон таацуулж дэс /код/ зурлагаар таниулжээ.

85.12

Э 66

/НХУУТ-1/

ЭШФ Т-22961

Нанжид Д. **Монгол бүжиг:** Сургалт, судалгаа, дэг зохиомж / Эмхт. Ш.Эрдэнэцэцэг, Ж.Эрдэнэхорлоо, Д.Мэндбаяр.- УБ.: Жиком пресс, 2017.- 480х.- ISBN: 978-99978-961-1-7.



МУГЖ. Д.Нанжидын бүжгийн урлагийн арга техникийн талаар бичсэн эдүгээ олдохоо больсон таван номыг нь нэгтгэж нэгэн томоохон бүтээл болгон гаргаж буй энэ номонд монгол ардын бүжгийн үндсэн дасгалууд, бүжгийн намба төрх, үндэсний өвөрмөц онцлог, дэг зохиомж, түүхэн өв уламжлал, хөгжлийн шинэ хандлага, бий бийлэхийн гайхамшиг болон угсаатны бүлгүүдийн бүжгийн тайз, хувцасны соёл зэрэг бүжгийн урлагт хамаарах өргөн агуулгыг хамарсан байна.

85.32(1)

Н 282

ЭШФ Т-22870-22871

Соёл урлагийн тайлбар толь / Ерөн. ред. Э.Сонинтогос.- УБ.: Мөнхийн үсэг.- (Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургууль. Соёл Урлаг судлалын Хүрээлэн). **Б. I: Дүрслэх урлаг.**- 519х.- 2016.- ISBN: 978-99962-57-92-6.



Монгол угсаатны урлахуйн нэршил, тайлбар хийгээд шинэ үеийн дүрслэх урлагт орж ирсэн нэр томъёо, орчин цагийн урлагийн зүтгэлтэн, эрдэмтэн судлаачид, эрх зүйн баримт бичгүүд, ном судалгааны бүтээл, үзэсгэлэн

тэргүүтнийг эрэмблэн нэгтгэж, улмаар шилдэг бүтээлийн дээжис болох нэгжээд баримтыг баримтжуулан багтааж, тайлал тайлбар хийсэн дүрслэх урлагийн эл толь бичгийг уншигч олноо өргөн барьсан болой.

85.1

C-52

ЭШФ Т-18290, 22784-22785

Б. III: Музей.- 478х.- 2017.- ISBN: 978-99978-961-3-1.

Энэ толь бичигт музейн түүх, хөгжил дэвшлийг бүтээлцсэн гавьяатай хүмүүсийн товч намтар, музейн байгууллагууд, ном судалгааны бүтээлүүд, хууль тогтоомж, үнэт ховор үзмэрүүд, радио нэвтрүүлэг, хөшөө дурсгал, музейд холбогдох нэр томъёоны мэдээлэлийг толгой үгээр үсэг дараалалд оруулан гэрэл зурагтайгаар тайлбарласан байна.

79.1я2

M 865

ЭШФ Т-22793-22794



Б. IV: Хөгжим.- 398х.- 2018.- ISBN: 978-99978-733-9-2.

Энэхүү толь бичигт монголчуудын бүтээн цогцлоосон хөгжмийн зэмсэг, дуу хөгжмийн төрөл зүйл, хөгжмийн урлагийн байгууллага, сургууль соёл, ном судар, бүтээл туурвил болоод энэхүү хөгжмийн урлагт авьяас билгээ зориулан уран бүтээлээ туурвиж ирсэн алдартнуудын түүхийг товчлон багтаажээ.

85.31я2

X 545

ЭШФ Т-22795-22796



Б.V: Бүжиг.- 321х.- 2018.- ISBN: 978-99978-733-8-5.

Бүжгийн урлагаар анх хэвлэгдэн гарч буй энэ толь бичигт манай шинэ цагийн бүжгийн урлагийн үүсэл, хөгжил дэвшил, ардын бүжгийн хувь бодгаль урын сан хэрхэн бий болсон хийгээд тайзны бүжиг, бүжгэн жүжиг, бүжгэн туульс болтлоо өсөж өндийсөн түүх, түүний гол гол төлөөлөгчдийн товч намтар, монгол урлагийн түүхэнд хувь нэмрээ оруулсан бүтээлүүдийн тухай хамгийн чухал мэдээлэл болон шүүмжийн гол бүтээлүүдийг оруулжээ. Мөн урлагийн байгууллага, хамтлагуудын мэдээлэлийг толгой үг болгон дараалалд оруулсан нь бусад толиос давуу талтай болсон байна.

85.32я2

Б 831

ЭШФ Т-22797-22798



Энхдаваа Д. **Хөх дарх** / Ред.Ч.Болдбаатар.- УБ.: Адмон, 2016.- 224х.- ISBN: 978-99973-68-43-0.

Монгол үндэстний сонгодог өв уран дархны урлагийг өвлөн уламжлах, хадгалан хамгаалах, судлан шинжлэх, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор эрдэмтэн судлаачид, уран бүтээлчид, сонирхогчдод гарын авлага



болгон бүтээсэн тус нэгэн сэдэвт бүтээлд монголчуудын эртний дархлах урлагийн арга хэлбэр, урлах жор, дархны багаж хэрэгслийн төрөл зүйлийн судалгааг баримт мэдээ, түүхийн дурсгал, хууч судлалын олдворт тулгуурлан хүй эртний хүрлийн үеэс түүчээлэн XX зуунаа нэхэн судалсан нь уг судалгааны шинэлэг тал төдийгүй дүрслэх урлагийн судлалд гарч байгаа шинжлэх ухааны дэвшил болсон ажээ.

85.12

Э 66

/НХУУТ-2/

ЭШФ Т-22804-22806

Соронзонболд С. **Хөгжим хэмээгч тэнгэр газрын найрамдах болой** / Ред. Д.Дашжамц.- УБ.: Жиком пресс, 2019.- 262х.- ISBN: 978-99978-69-32-6.

Хөгжмийн зохиолч, судлаач С.Соронзонболд нь энэхүү нэг сэдэвт бүтээлдээ Хубилай хааны ордны төрийн ёслол журамд ёслол хөгжмийг үүсгэхдээ хөнгөн хуурмаг сэтгэлээс биш хичээнгүй төв эв эеийн үйлийг бодож хийдэг байсан тухай Эртний Юань улсын сударт тэмдэглэн үлдээсэн эх сурвалжид тулгуурлан судлахдаа хүмүүний сэтгэлийн хэлийг дэлгэрүүлэн тайлбарлажээ. Мөн Үүл найрамдах буюу хөгжим нэгэн аймаг буюу Юань улсын ордны найрал хөгжимчдын буюу бие бүрэлдэхүүн, тэдний хувцас эдлэлийн талаар сонирхолтой судалгаа хийжээ.

85.31

С 599

ЭШФ Т-22801-22803



Энхцэцэг Д. **Хуурын татлага-Монголын хөгжимт соёлын феномен болох нь** / Ред. Н.Жанцанноров.- УБ.: Бэмби сан, 2018.- 136х.- ISBN: 978-99978-756-2-4.

Энэхүү бүтээлд Монголчуудын олон зуунаар уламжилсан хуурын гарал үүсэл, төрөл зүйл, хийц хэлбэр, хуурдах дэг сургууль, угсаатны онцлог, газар зүйн тархалт, урын сангийн бүрдэл зэргийг хөгжмийн онол-түүхийн судалгааны өнөөгийн ололт туршлагад тулгуурлан шинээр томъёолон цэгцэлж хуурын олон төрөл зүйлийн зэмсгийн төгс боловсорсон “төв” зэмсэг нь эдүгээ цагийн морин толгойтой (морин хуур) болохыг нэг мөр тодруулан тодорхойлсон байна.

85.31

Э 661

ЭШФ Т-2022799-2022800



ШАШИН СУДЛАЛ

Алтанзаяа Л. **Монголын тамгатай хутагтуудын шавь нар** / Ред. Ш.Сонинбаяр.- УБ.: Хаан принтинг, 2011.- 290х.- ISBN: 978-99962-55-15-1.

Судлаач Монголын нийгэмд 300 орчим жилийн турш оршин тогтносон тамгатай хутагтуудын засаг захиргааны тогтолцооны үүсэл бүрэлдэл, хувирах өөрчлөлтийг судлахдаа тухайн түүхэнд холбогдох сурвалж бичгүүдэд тулгуурлаж, улс төр, нийгмийн нөхцөл байдалтай нь холбон судалсан байна. Ингэхдээ МУ-ын Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй баримтад тулгуурлан Жавзандамбахутагт болон бусад тамгатай хутагтууд, тэдгээрийн сүм хийд,



шавь нарын түүхэнд холбогдох баримтуудыг аймаг, шавь хошуудаар нь ангилан авч үзжээ.

86.35(1)

А 486

ЭШФ Б-29342

ГҮН УХААНЫ ШИНЖЛЭХ УХААН

Төрийн албан хаагчийн ёс зүй: Гарын авлага / Боловс. Г.Мягмар, М.Нармандах, Ч.Ундрэм; Хян. Д.Дуламсүрэн.- УБ.: Урангар пресс, 2019.- 144х.- (Авлигатай Тэмцэх Газар).



Төрийн захиргааны болон үйлчилгээний хаагчийн ёс зүйн дүрэм батлагдан хэрэгжиж эхэлж буй энэ мөчид төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн онолын үндсэн ойлголт, үнэт зүйлс, баримтлах зарчмууд, ёс зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам, төрийн албан хаагчийн манлайлал ба ёс зүйн ухагдахуун болон төрийн албаны ёс зүйг дээшлүүлэх сайн туршлага ба боломжуудын талаар тус гарын авлагад өгүүлсэн байна.

87.75

Т 594

/НХУУТ-1/

ЭШФ Т-22886

СЭТГЭЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААН

Сэтгэл судлалын түүх / Орч. Эмхт. П.Одгэрэл; Хян. П.Гантуяа.- УБ.: Соёмбо принтинг, 2019. – 148х.- ISBN: 978-9919-21-024-3.



Энэ номонд сэтгэл судлалын ухааны хөгжлийн түүхэн үеийг эртний болон дундад зууны, сэргэн мандалтын үе гэж хуваан тухайн цаг үеийн төлөөлөл болсон эрдэмтдийн тодорхойлолт, санал дүгнэлтээс тоймлон оруулсан байна. Мөн түүнчлэн сэтгэл судлалын салбаруудын хөгжил, урсгал чиглэлүүдийн судлагдахууны талаар өгүүлжээ.

88.1

С 974

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29336-29338

Байгаль Ө., Нандинцэцэг Б. **Хүүхдийн зан байдлыг сайжруулах сэтгэц заслын үндсэн арга, техник /** Ред. М.Нарантуяа.- УБ.: Бит пресс, 2019.- 75х. ISBN5 991921134-6



Энэхүү гарын авлагад зөрүүдлэх, зожигрох, хэрцгий догшин авир гаргах, хүний юманд зөвшөөрөлгүй хүрэх, авах, түрэмгий шинжүүдийг авч үзсэн ба тэдгээрт хамгийн оновчтой гэж үздэг сэтгэц заслын тоглоомын буюу Play Therapy, элсэн буюу Sandplay Therapy, танин мэдэхүйн буюу Cognitive Behavioral Therapy, хөгжмийн буюу Rational Emotive Therapy, зуран Picture Therapy, хөгжмийн буюу Music Therapy зэрэг аргуудыг тайлбарлажээ.

88.8

Б 174

/ГНОФ-10, НХУУТ-7/

ЭШФ Т-2022853-2022855

Мөнхцэцэг Д. **Донтолт ба сэтгэл зүйн зөвлөгөө** / Ред. Ш.Эрдэнэчимэг, Б.Цэрэнлхам.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 222х.- ISBN: 978-9919-21-148-6.



Өнөөгийн нийгмийн нэн тулгамдсан асуудлын нэг донтолт нь сэтгэцийн эмгэг өвчин болтлоо даамжирч байгаа энэ цаг үед судлаач энэхүү бүтээлдээ мансууруулах бодис, архи, интернэт, мөрийтэй тоглоом, секс донтолтын шалтгаан, үр дагавар, шалгууруудын тухай тайлбарлаж, тэдгээрт тохирсон сэтгэл зүйн зөвлөгөөний арга зүй, заслудыг өөрийн судалгаандаа үндэслэн боловсруулсан заавар зөвлөгөөний хамт багтаан эмхэтгэжээ.

88.3

М 816.

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-22850-22852

ЛАВЛАГАА НОМ ЗҮЙН ГАРЫН АВЛАГА

Монгол улсын Үндэсний номын сан дахь архивын бүртгэн мэдээлэх номзүй / Эмхт. Д.Энхтунгалаг, Х.Ундрах; Ерөн.ред. Д.Энхтунгалаг.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- (Монгол Улсын Үндэсний Номын Сан). Б.6: 2010-2018 он.- 508х.- ISBN: 978-99978-4-371-5.



МУ-ын Үндэсний номын сан нь 1921 оноос өнөөг хүртэл монгол улсад хэвлэгдсэн ном бүрээс авч архивлан хадгалж ирсэн бөгөөд тус архив фондод хадгалагдаж буй 1921-2010 онд хэвлэгдсэн номын ном зүйн мэдээлэлийг агуулсан 5 боть бүртгэлийг эмхэтгэн олны хүртээл болгосон. Түүний үргэлжлэл болох энэхүү 6-р ботид 2010-2018 онд тус фондод нэмэгдсэн 6960 номын ном зүйн мэдээлэлийг нэрийн үсгийн дараалалаар байрлуулж, төгсгөлд нь хүний нэрийн хэлхээсийг хийж өгсөн байна. Уг ном зүйн бүртгэл нь эрдэмтэн судлаачид, номын сангийн ажилтнууд, нийт уншигчдад зориулагдсан болно.

91

М 69

/Лав-1/

ЭШФ Т-22829-22831